



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН
ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 182/ШШ2019/00557

Улаанбаатар хот

Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг
баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Н.Нарангэрэл би,

Нэхэмжлэгч: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Нью майнд групп ХХК-ийн
байранд байрлах, Лэндмн ББСБ ХК-ийн нэхэмжлэлтэй,

Хариуцагч: Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо, Булгийн 15 гудамж 643^б тоот
хаягт оршин суух, Г.Тэмүүжинд холбогдох

Зээлийн гэрээний үүрэгт 386,276 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийг
хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХК шүүхэд болон төлөөлөгч А.Билгүүн шүүхэд
бичгээр гаргасан хүсэлтдээ: Г.Тэмүүжин нь 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр
37474 дугаартай цахим зээлийн эрх нээх гэрээг байгуулсан. Г.Тэмүүжингийн
Lendmn аппликейшнаар дамжуулан гаргасан хүсэлтийн дагуу 2017 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр 340,000 төгрөгийн зээлийг 24,200 төгрөгийн шимтгэлтэй, 30
хоногийн хугацаатай 2018 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр бүрэн эргэн төлөх
нөхцөлтэй, 340,000 төгрөгийг Г.Тэмүүжингийн Хаан банкны 5065226619 тоот
дансанд шилжүүлсэн. Иймд Г.Тэмүүжингээс үндсэн зээлийн төлбөр үндсэн зээлийн
дүн болох 340,000 төгрөг, шимтгэл 24,200 төгрөг, нотариатын үйлчилгээний төлбөр
22,076 төгрөг, нийт 386,276 төгрөгийг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан. Г.Тэмүүжин
нь 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр 386,276 төгрөгийг барагдуулж дууссан тул
нэхэмжлэлээсээ татгалзаж байна. Дахин нэхэмжлэл гаргахгүй, төлбөр тооцоо
дууссан гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХК хариуцагч Г.Тэмүүжинд холбогдуулан зээлийн
гэрээний үүрэгт 386,276 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Талуудын хооронд 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр 37474 тоот цахим
зээлийн эрх нээх гэрээ байгуулагдаж, 340,000 төгрөгийг 30 хоногийн хугацаатай
2018 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр эргэн төлөх нөхцөлтэй, 24,200 төгрөгийн
шимтгэлтэй зээлсэн тухайд маргаагүй байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХК
нь хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлсэн үндэслэлээр нэхэмжлэлээсээ
татгалзсан тайлбараа шүүхэд бичгээр ирүүлсэн нь бусдын эрх, эрх чөлөө, хуулиар

006054

хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй, хуульд харшлаагүй байх тул нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох үндэстэй гэж үзлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 75 дугаар зүйлд заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Лэндмн ББСБ ХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч Г.Тэмүүжинд холбогдох зээлийн гэрээний үүрэгт 386,276 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийн нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан татгалзлыг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5 дахь хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 12,238 төгрөгийг Улсын орлогод хэвээр үлдээж, Улсын орлогоос 6,119 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгосугай.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4 дэх хэсэгт зааснаар зохигч давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болохыг дурдсугай.

ШҮҮГЧ



Н.НАРАНГЭРЭЛ